



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.07.07 № 1152  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ  
НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Хөдөлмөрийн үндэсний намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Хөдөлмөрийн үндэсний намын нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн


Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хөдөлмөрийн үндэсний намын мөрийн хөтөлбөр 1.6 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэл, дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 1.6 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР







Хөдөлмөрийн үндэсний намын  
Төлөөлөх зөвлөлийн 2020.07.06-ны өдрийн  
хурлын 03 дүгээр тогтоолын 1-р хавсралт

## Нийслэл, Нийслэлийн дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох

### Хөдөлмөрийн үндэсний намын СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ХӨДӨЛМӨРИЙН  
ҮНДЭСНИЙ НАМ

тамга



2020 он  
Улаанбаатар хот



## АГУУЛГА

ОРШИЛ .....	2
I. ХҮНДЭЭ ЭЭЛТЭЙ ХОТ .....	3
II. ТЕХНОЛОГИЖСОН ХОТ .....	6
III. НОГООН ХОТ.....	7
IV. ХҮНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ХОТ .....	9
V. БИЗНЕСТ ЭЭЛТЭЙ ХОТ .....	13





## ОРШИЛ

Хөдөлмөрийн үндэсний намын 2020 оны Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан баримт бичиг болно.

Монгол оронд сүүлийн жилүүдэд үүссэн ардчиллын болон тогтолцооны гажуудлыг засч, үндэсний язгуур эрх ашиг, түүх соёл, уламжлал, эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, дэлхийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хүний хөгжил, хууль ёс, шударга ёс, нийгмийн ардчиллыг дээдэлсэн хүмүүнлэг, аз жаргалтай нийгмийг цогцлоон байгуулах зорилгоор, Монгол Улсын хөгжлийн үрт хугацааны зорилтыг ханган биелүүлэх хүрээнд, нотолгоонд суурилж, судалгаанд үндэслэн энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулав.


Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, түүний дүүргүүд төлөвлөснийхээ дагуу хөгжиж, дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэн алхья гэвэл дотоодын жижиг зах зээлд хоорондоо хэт өрсөлдөж, хүч нөөцөө барах бус, олон улсын зах зээлд өрсөлдөх зарчмыг баримтлах нь чухал тул тулгарч буй асуудлаа эрэмбэлж, орчин үеийн хотын хөгжлийн стратеги боловсруулах шаардлагатай.

Хөгжлийн стратеги нь нэн тэргүүнд Нийслэлийн иргэн хүний төлөө хүний хөгжлийг эн тэргүүнд тавьж, бусад салбаруудыг хөтлөх, хөгжлийн салхийг чиглүүлэх юм. Монгол Улсын орчин, нөхцөл байдал, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзвэл дараах 3 чиглэл онц ач холбогдолтой бөгөөд эдийн засаг, нийгмийг хөгжлийн замд нь түргэн гаргахад түлхэц болно гэж бид үзэж байна. Үүнд:

- (1) Хүний хөгжил.** Боловсрол, эрүүл мэнд, хүний хөгжилд тууштай, бодитой хөрөнгө оруулах. Нэгд, энэ асуудал өнөөдрийн Монгол улсад, нийслэл хотод нэн тулгамдсан, хойш тавих боломжгүй асуудал, хоёрт, дунд болон үрт хугацаанд олон том асуудлын шийдэл нь хүний хөгжил юм.
- (2) Технологийн хэрэглээ.** Блокчэйн, хиймэл оюун ухаан, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын технологийн шийдлүүд, нанотехнологи, биотехнологи, хөдөө аж ахуй, эрчим хүч, химийн болон бусад салбарт технологийн дэвшлийг төр, бизнесийн бүх түвшний хэрэглээнд хурдтай бөгөөд бусдаас өрсөн шийдэмгий нэвтрүүлэн, өрсөлдөөний давуу талыг олж, үр шимийг нь түрүүлж хүртэнэ.
- (3) Байгальд ойр Монгол.** Байгаль дэлхийтэйгээ шүтэн барилдсан уламжлалт монгол сэтгэлгээ, нүүдлийн соёл, амьдралын амар тайван хэв маягийг технологийн шийдэлтэй хослуулан хотын гэр хорооллыг хөгжүүлж, дэлхий дахинд ялгарах шинэ Монгол дүр төрх бүрдүүлнэ.

Нийслэлийн иргэдэд хурд, хүч, ялгарлыг өгөх дээрх гурван тулгуурт үндэслэн нэн тэргүүнд хэрэгжүүлэх ёстой бодлогын арга хэмжээг дараах 5 бүлэгт ангилан оруулав. Үүнд:

- 1. Хүндээ ээлтэй хот – Цэвэр хот, цэмцгэр гэр хороолол.**
- 2. Технологижсон хот - Шилдэг шинэ технологийг нэвтрүүлж орчин үеийн хотыг хөгжүүлнэ.**
- 3. Ногоон хот - Орчны бохирдлыг бууруулж, хүн амын эрүүл ахуйн баталгааг тогтвортой хангана.**
- 4. Хүндээ үйлчилдэг хот – Төрийн үйлчилгээг иргэн тус бүрт тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэнэ.**
- 5. Бизнес ээлтэй хот – Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна.**



2






## 1. ХҮНДЭЭ ЭЭЛТЭЙ ХОТ

Цэвэр хот, цэмцгэр гэр хороолол


Иргэдийн аюулгүй, ая тухтай амьдрах орчныг стандартаар баталгаажуулсан хот төлөвлөлтийг хэрэгжүүлж, газар олголт, газрын эзэмшлийн асуудлыг шударга шийдвэрлэнэ.

Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.

- Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд, хог хаягдлыг дахин боловсруулж, Улаанбаатар хотыг утаагүй хот болгоно.
- Хотын төвийн хэсэгт орон нутгийн болон засгийн газрын өмчлөлд үлдсэн газрыг зөвхөн нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, спортын талбай, амралт зугаалгын ногоон байгууламж байгуулахад ашиглах тухай хуульчлан зохицуулна.
- Олгож үл болох, хамгаалах шаардлагатай газрын жагсаалт үүсгэж, нийтийн хэрэгцээнд ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
- Нягтаршилт хэтэрсэн орон сууцны хороололд ногоон байгууламж, тоглоомын талбай, амралт зугаалга, автомашины зогсоолоос өөр төрлийн барилга байгууламжийг шинээр барихыг хуулиар хориглоно.
- Шинэ суурьшлын бүс, дагуул хотыг хөгжүүлэхдээ төрийн өмчөөр зөвхөн төлөвлөлт хийж, дэд бүтцийг шийдвэрлэх ба барилгажилтын талбайг нээлттэйгээр дуудлага худалдаанд хамруулан хөрөнгө оруулалт босгох замаар орон сууцны хорооллыг өргөтгөнө.
- Орон сууцны хороолол, гэр хорооллын дунд ногоон байгууламж, соёл, спортын төвүүдийг байгуулах талаар хүн амын тоо, нягтаршилаас хамааруулан хүртээмжтэй байх стандарт батлуулж, мөрдүүлнэ.
- Хотын ой санамжийг хадгалсан уран барилга, түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг шинэчлэн баталж, төрийн хамгаалалтанд авч, сэргээн засварлаж хойч үедээ өвлүүлэн үлдээх бодлого баримтлана.
- Иргэд, хүүхдүүдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, нийтийн үйлчилгээний газар, орон сууцны нийтийн эзэмшлийн талбай зэрэгт эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын стандартыг чанд мөрдүүлнэ.
- Нийслэлийн хүүхдийн паркийг бүхэлд нь олон нийтэд нээлттэй, тайван амарч зугаалах цэцэрлэгт хүрээлэн болгон тохижуулна.
- Спорт цогцлоор, биеийн тамирын заал, талбай, цэцэрлэгт хүрээлэн, дугуй болон дугуйн төрөлт тээврийн замыг 1000 хүн тутамд нэг байхаар байгуулах зорилт тавьж, энэхүү зорилтод хүрэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлнэ.
- Орон сууцны хороолол, хотхонуудыг авто зам, явган хүний замын нэвт гарцтай болгож шаардлагагүй хашаа, хашалыг буулгаж ногоон зурвасыг нэмэгдүүлнэ.



3






- Дүүргүүдийн хүүхэд залуучууд, ахмад настнуудад зориулсан сургалт, соёл, хөгжлийн төвүүдийг дэмжих арга хэмжээ авна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг хангах чиглэлээр олон улс болон Монгол Улсын хууль, журмыг баримталж, нийтийн тээвэр, үйлчилгээний газар, сургууль цэцэрлэг, барилга байгууламж зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан норм дүрмийг ягштал мөрдүүлнэ.
- Төрийн байгууллагуудын барилгуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 100 хувь хүртээмжтэй болгоно.
- Нийслэлийн зам, гудамж талбайн ашиглалтыг автомашинд бус явган зорчигчдод давуу эрх олгох зохицуулалтыг баталгаажуулж хэрэгжүүлнэ. Явган хүний зам, дугуйн замын стандартыг мөрдүүлж, аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлнэ.
- Нийтийн тээврийн хэрэгслийг тусгай эгнээгээр давуу эрхээр зорчуулж, үйлчилгээний хуваарийг тогтмолжуулна. Улмаар тусгай замын автобус, троллейбусд хөрөнгө оруулж, нийтийн тээврийн тоо, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Хүүхдийн аюулгүй байдлыг хангахад онцгойлон анхаарч, 6 хүртэл насны хүүхдийг гэртээ ганцаар байхыг хориглон, хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэгийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана.

### Цэмцгэр гэр хороолол

- Нийслэл, дүүргийн гэр хороолол хөрөнгө оруулалтын гадна үлдэж хоцордог шударга бус байдлыг эцэслэж, дэд бүтцийн бүтээн байгуулалтанд хөрөнгө оруулалтыг түлхүү хуваарилах бодлого баримтлана.
- Агаар ба хөрсний бохирдлыг бүрэн шийдвэрлэх зорилгоор гэр хорооллыг хувийн сууц, нийтийн орон сууц хосолсон тохилог хороолол болгох хөтөлбөр хэрэгжүүлж эхэлнэ.
- Гэр хорооллын иргэд хашаандаа цэвэр бохирын төвлөрсөн болон бие даасан шийдэл бүхий дулаан сууц барихад ипотекийн зээл олгох ажлыг өргөн цар хүрээтэйгээр хэрэгжүүлнэ. Гэр хороололд олгох ипотекийн зээлийн эх үүсвэрийн хэмжээ орон сууцны хорооллоос их байна, харин хүү нь бага байхаар зохицуулах ба үүнд олон улсын банк, санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй эх үүсвэрийг түлхүү ашиглана.
- Гэр хорооллын иргэд хоршоо байгуулж, өөрсдийн эзэмшлийн газартаа хэсэгчилсэн дэд бүтцийн шийдэлтэй орон сууцны хороолол байгуулж, зарим хэсгийг борлуулан ашиг олох төслүүдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих бодлого баримтлана.
- Гэр хороололд мод, ургамал тарих, арчилахад иргэд, байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Үүнд олон улсын ногоон санхүүгийн эх үүсвэрийг түлхүү ашиглана.
- Шинээр барих орон сууцны хорооллуудыг нийгмийн дэд бүтэц, цэцэрлэг, сургууль, нийтийн ахуйн үйлчилгээ үйлчилгээ, нийгмийн бүлгүүдэд зориулсан төвүүд, бизнес, аж ахуйн дэд төвүүдтэй байхаар төлөвлөх.






## Орон сууцны хороолол

- Нийтийн орон сууцны хуучирсан барилгуудын гаднах фасадыг шинэчилж, стандартад нийцүүлэн дулаалж, сантехникийн шугам сүлжээг шинэчлэх замаар орон сууцны насжилтыг уртасгах ажлыг Зүүн Европын улсуудын жишгээр төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах бодлого баримтлана. Үүнд олон улсын банк, санхүүгийн байгууллагын хөнгөлттэй эх үүсвэрийг түлхүү ашиглана.
- Сууц өмчлөгчдийн холбооны тогтолцоог эргэж харан, гажуудлыг засч, төгөлдөршүүлнэ.
- Орон сууцанд дулааны тоолуур тавих замаар өртөг зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- Залуу гэр бүлийн орлогод нийцсэн орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх бодлого баримтлана.
- Хүн амын цэвэр усны хангамж, усны чанарыг сайжруулах, цэвэр усны шинэ эх үүсвэрийг ашиглалтанд оруулах. Үүнд олон улсын хөнгөлөлттэй зээл, ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг түлхүү ашиглана.
- Хуучин автомашины гаражууд олноор төвлөрсөн, дахин төлөвлөлт хийх боломжтой байрлалуудад багтаамж ихтэй дулаан зогсоолууд байгуулна. Үүнд НОСК, ТОСК-ийг ашиглах ба илүүдэл зогсоолыг борлуулах замаар төсөвт дарамт учруулахгүйгээр зохион байгуулна.

## Цэцэрлэг, сургуулийн сургалтын орчныг сайжруулна

- Цэцэрлэг, сургуулийн эргэн тойрны газар ашиглалтын байдалд аудитын дүгнэлт хийлгэж, төрөөс хүүхдэд таатай гадаад орчин бүрдүүлэхэд анхаарна.
- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдүүдийг бүрэн хамруулах зорилгод хүрэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлнэ.
- Нэг ээлжинд хичээллэдэг тогтолцоог зорилт болгон энэхүү зорилтод хүрэх арга хэмжээг авч эхлүүлнэ.
- Цэцэрлэг, сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурах, ашиглах бүрэн боломжтой байх стандартыг нэвтрүүлж хэвшүүлнэ.



5





## II. ТЕХНОЛОГИЖСОН ХОТ

### *Шилдэг шинэ технологийг нэвтрүүлж орчин үеийн хотыг хөгжүүлнэ*

- Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлнэ. Хот суурин, орон нутгийн бүх түвшинд интернэт, компьютер, технологийн хэрэглээг түлхүү ашиглах, интернэт орчинг хүртээмжтэй, хурдтай байлгах, мэдээллийн технологи хөгжих суурь нөхцлийг бүрдүүлнэ.
- Нийслэлийн хүн амын 95 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн үрсгалын хэмжээг арав дахин нэмэгдүүлнэ.
- Эрчим хүчний олон төрлийн эх үүсвэрийг ашиглах, бага, дунд оврын үүсгүүрийн технологи хөгжүүлэх, аж ахуйн нэгж, хувийн сууц, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол гэх мэт барилга байгууламжид нар, салхи, газрын гүний дулааны эрчим хүчний эх үүсвэрийн ашиглалтыг дэмжих бодлого баримтлана.
- Онлайн сургалт. Хөгжлийн хандлагыг даган танхимын бус, зөвхөн хүүхэд залуус биш бүх насны хүмүүст зориулсан онлайн, эчнээ сургалтуудыг нэвтрүүлэх, хүн өөрийгөө хөгжүүлэх боломжийг технологид суурилан олноор бий болгоно.





### III. НОГООН ХОТ

*Орчны бохирдлыг бууруулж, хүн амын эрүүл ахуйн баталгааг тогтвортой хангана*

Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлэх зорилгоор арга хэмжээ авна.

- Хог хаягдлыг бууруулах, ангилан хаях, дахин ашиглах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хог хаягдлыг цуглуулах тогтолцоог ядуурлыг бууруулахтай үялдуулан хэрэгжүүлнэ.
- Нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт байгаль дахь хог хаягдлыг арилгах, түүж цуглуулах тогтолцоог боловсронгуй болгож, аялал жуулчлалын орлогоос хог хаягдлыг бууруулах менежментийг санхүүжүүлнэ.
- Нийслэлийн хэмжээнд агаар, ус, хөрс бохирдуулагч эх үүсвэрийн тооллого, тогтмол хяналтыг хийж, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлдэг болно.
- Усны бохирдлыг бууруулна. Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг түсгай хамгаалалтад авч, хүр тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх зорилгоор арга хэмжээнүүдийг авч эхэлнэ.
- Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 85 хувьд хүргэж, хүн амын 50 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжийг барих зорилгоор арга хэмжээг авч эхлүүлнэ.
- Хаягдал усыг цэвэршүүлэх, саарал ус ашиглах, хурын усыг хуримтлуулах гэх мэт усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, усны төлбөрийг хөнгөлөх зохицуулалтыг хуульчилна.
- Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгохыг бодлогоор дэмжиж, Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулна.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгоно.
- Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт малчин айлд очих, тодорхой хугацаанд ажиллаж, ахуй соёлоос суралцах байгаль орчноо хамгаалах агуулгыг нэвтрүүлнэ.





- Байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 5 дахин нэмэгдүүлэх.
- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах бодлого баримтлана.
- Хүлэмжийн хий бууруулах, байгаль хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга, ногоон төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, санхүүжилт, хөрөнгө оруулалт татах зориулалттай төр хувийн хэвшил хамтарсан санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх бодлого баримтлана.
- Хувийн хэвшлийн оролцоо, хариуцлага, хөрөнгө оруулалтыг түлхүү татан оруулах, ногоон зээл санхүү, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын орчин бий болгоно.





## IV. ХҮНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ХОТ

*Төрийн үйлчилгээг иргэн тус бүрт тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэнэ*

### Сайн боловсрол хөгжлийн үндэс

- Улсын үндэс нь болсон иргэнээ дээдэлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, ахмадаа хүндэлдэг, хүүхэд балчираа хайрладаг, өндөр ёс суртахуунтай, журам жудагтай монгол иргэнийг хөгжүүлэхийг эрхэмлэнэ.
- Хууль журмыг ягштал биелүүлдэг, бусдыг хүндэтгэдэг, цаг баримталдаг, үнэний төлөө, зөвийн төлөө, шударгын төлөө түүштай тэмцэх ёс зүйн хүмүүжлийг бага наснаас нь суулгах, нийгмийг гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.
- Эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, иргэний эрх, үүргээ ухамсарлан биелүүлдэг, ёс зүйтэй, хариуцлагатай, үндэсний бахархал, эв нэгдлийг эрхэмлэдэг иргэдийг төлөвшүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсролыг “хүүхдийг сургах, сургуульд бэлтгэх” гэсэн зорилгоос илүүтэйгээр хүн болон төлөвших үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан түршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ.
- Шавь төвтэй, бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх сургалтын арга барилыг бэхжүүлнэ.
- Бага сургуулийн сургалтыг хэт академик байдлаас ангижруулж, чадварт суурилсан, хүүхэд бүрийг ахицаар нь үнэлдэг тогтолцоонд шилжүүлнэ.
- Бүх шатны боловсрол олгоход технологийн болон байгалийн ухааны сургалтын чанарыг дээшлүүлнэ. Сургуулиудад байгалийн ухаан, хөгжим, технологийн хичээлийн лаборатори байгуулах ажлыг төсвөөр дэмжинэ.
- Бүрэн дунд боловсролыг мэргэжлийн сургалттай хослуулсан аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн гүнзгийрүүлсэн сургалтыг төрөөс дэмжинэ.
- Нийслэлийн хэмжээнд “Хос хэлтэн” болох зорилт тавьж, зохих бэлтгэл ажлыг хэрэгжүүлнэ. Гадаад хэлний мэдлэгийг түлхүү анхаарч, танхимын болон онлайн сургалтыг эрчимтэй нэвтрүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлээс үл хамаарсан тэгш хамруулан сургалтыг ерөнхий боловсролд бүрэн нэвтрүүлэхийг дэмжинэ.
- Сурагчдын насны онцлогт тохирсон эрүүл мэндийн мэдлэг болон дадал хэвшлийг системтэйгээр олгоно. Ахлах ангийн сурагчдыг гамшгаас хамгаалах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэдлэг олгох сургалтанд хамруулна.
- Сурагчдыг нийгмийн харилцаанд ороход нь бэлтгэж, сэтгэл судлал болон хүн хоорондын харилцааны соёлын талаарх хичээлийг боловсролын хөтөлбөрт тусгана.
- Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалтыг арилгах тогтолцоог бэхжүүлж, хүүхдэд аюулгүй цахим орчныг бүрдүүлнэ.
- Хүүхдийн зүй бус, албадан хөдөлмөр, мөлжлөгийг устгах, сургууль завсардалтыг үндсээр нь хална.







## Боловсролын тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлж, багшлах боловсон хүчнийг бэхжүүлнэ.

- Нийслэл, дүүрэг, орон нутгийн боловсролын газар, Багшийн хөгжлийн институт, орон нутаг, яамны чиг үүргийн давхцлыг арилгах, эрх үүргийг тодорхой болгоно. Багшийн үндсэн болон нэмэлт цалингийн өнөөгийн төвөгтэй тогтолцоог хялбаршуулж, үндсэн цалинд шингээн тооцдог тогтолцоонд шилжинэ.
- Багшийг дахин сургах, гадаадад сургах, түршлага солилцуулах “1000 багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Сургуулийн барилгын стандартыг шинэчилж, зураг төслийн зардлыг хэмнэх зорилгоор орон нутгийн онцлогт тохирсон ижил стандартуудтай болгоно.
- Сургуулийн эргэн тойрныг цэцэрлэгжүүлэх, биотоп байгуулах, цаг уурын ажиглалтын станц байгуулах замаар байгалийн ухааны хичээлийн туршилтын талбай болгон ашиглахыг төрөөс дэмжинэ.
- Боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг хангах, чанарыг дээшлүүлэх зорилгоор зайн сургалт, онлайн сургалтыг нэвтрүүлэхийг төрөөс дэмжинэ.
- Сургуулийн орчинг өндөр хурдны интернэтэд бүрэн холбох, сургалтад ашиглах боломжийг бүрдүүлнэ.
- Сайн сургуулийн жишгийг боловсруулж, “Сайн сургуулийг таны дэргэд” бодлогыг хэрэгжүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын эрдмийн зэрэг цолыг дээшлүүлэхэд нийслэлээс дэмжлэг үзүүлнэ.
- Багшлах боловсон хүчний тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- Сургууль, цэцэрлэг бүрийн гадаа биеийн тамирын талбай, тоглоомын талбай байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Ахлах сургуулийг мэргэжил олгох чиглэлд төрөлжүүлэн хөгжүүлнэ.
- Багшийн мэргэжлээр суралцаж буй оюутнуудад тэтгэлэг олгох боломжийг нэмэгдүүлж, 10, 15 жилдээ багшилж буй багш нарт олгох урамшууллыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

## Эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулна

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төсөв санхүү, нөөцийг нэмэн өргөжүүлж иргэдэд хүртээмжтэй ойртох нөхцлийг бий болгоно. Эрүүл мэндийн салбарын бодлого, төсөв, санхүүжилт, үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байдлыг бий болгож, авлига, ашиг сонирхлын тогтолцоог устгана. Эрүүл мэндийн салбарын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашгийг эрс сайжруулна.
- Эмч нарын мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх, салбарын шинэ технологи нэвтрүүлэх сонирхлыг нэмэгдүүлэх хөшүүргийг оновчтой нэвтрүүлж, уламжлалт анагаах ухааныг орчин үеийн шинжлэх ухаантай зөв хослуулна.







- Эрүүл мэндийн бүртгэлийн салбарт мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэх. E-Клиникийн тогтолцоог бий болгож, өвчин, үзлэгийн түүхийг үйлчлүүлэгч өөрөө эзэмшиж, өөрийн хүссэн эмнэлэг, эмчийн сонгон үйлчлүүлэх нөхцлийг хангана.
- Эмнэлгийн оношилгоонд хиймэл оюун ухаан, инноваци технологийг нэвтрүүлж, явуулын оношилгооны лаборатори болон эмнэлгийг нэвтрүүлнэ.
- Дүүрэг бүрт нийгмийн эрүүл мэндийн төв бий болгон, иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, дадал, хандлагыг өөрчлөх механизмыг бүрдүүлнэ.
- Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, эмчилгээний үйлчилгээг хөгжүүлж, олон нийтэд хүртээмжтэй, боловсронгуй болгоно.
- Архи, тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, бусад төрлийн донтолт, хорт зуршлын хамааралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх тогтолцоог сайжруулна. Архидалттай тэмцэх, архидалтыг сурталчилсан үүсмэл зан заншлыг халах, архидалтын эсрэг эмчилгээг хөгжүүлэхэд төрийн оролцоог нэмэгдүүлнэ
- Эрүүл мэндийн худалдан авалт, тоног төхөөрөмжийн импортын тогтолцоон дахь төр, хувийн хэвшлийн бүхий л харилцааг эрүүлжүүлнэ.
- Бүх шатны эмнэлгийн байгууллагын ажилтнууд, эмч, сувилагчдын нийгмийн байр суурь, үнэлэмж, хүндлэлийг нэмэгдүүлэх, эрүүлийг хамгаалах мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлнэ.
- Эмч, сувилагч нарын мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх, давтан сургалт, гадаад болон дотоод түршлага солилцох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарт дотоод гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтлана.
- Эрүүл мэндийн санхүүжилтийн бүтцийг оновчтой болгох замаар, эрүүл мэндийн даатгалын бие даасан байдлыг бэхжүүлэн, иргэд эрүүл мэндийн үйлчилгээг оршин суугаа газрын харьяалал, өмчийн хэлбэр үл харгалзан эрүүл мэндийн даатгалаараа бүх шатлалын үйлчилгээг авах боломжийг бүрдүүлнэ.
- Эмзэг бүлгийн иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг өрхийн эмнэлэг, хорооны нийгмийн ажилтны ажил үүргийн хуваарьт суулгаж хэрэгжүүлэх, бүртгэлд бүрэн хамруулна.

**Төрийн албан хаагчийг дэмжиж, төрийн үйлчилгээг цахимжуулна. Авлигын эсрэг нийтийн хөдөлгөөнийг дэмжинэ.**

- Мэргэжлийн, чадвартай, ёс зүйтэй төрийн албан хаагчдыг төрд тогтвортой ажиллуулна. Ийм бололцоог хангахын тулд төрийн албаны зөвлөлийг хараат бус, бие даасан инстүүц байгууллага болгоно.
- Төрийн албан хаагчдыг бэлдэх, тасралтгүй давтан сургана.
- Төрийн ёс зүй, сахилга бат, хариуцлага, мэдлэг чадвар, чармайлт бүхий төрийн тогтвортой албан хаагчдыг төлөвшүүлэн хөгжүүлэх бодлого, зорилт тавьж хэрэгжүүлнэ.






- Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.
- Төрийн үйлчилгээг цахимжуулж, ил тод нээлттэй болгож, хүнээс хамаарах хамаарлыг багасгаж, хүнд суртлыг бууруулах бодлого баримтлана.
- Авлига төрийн албанд голдуу үүрлэсэн боловч хүүхэд, залуу үеэ авлигач сэтгэлгээ суухаас сэргийлэх, өөрийн мэдэлгүй буруу хэвшил сургаж буй дадал, соёлыг засах, үхүүлга, сургалт таниулга хийх, олон нийтийн хөдөлгөөн болгох, нийгмийн бүх гишүүдийн оролцоо, дэмжлэгийг авна.
- Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд хуулийн салбарт үүссэн “хамжлагат” ёсыг халж, хараат бус, хуульд, төрд үнэнчээр зүтгэх, ёс зүйт, хүний эрхийн төлөө хандлагатай албан хаагчдаар бүрдүүлэх, тэдний эрхийг хангах нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг хангах бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ.

### Шударга, цэвэр, ёс зүйтэй Монгол хотыг бүтээнэ.

- Шударга ёсыг бэхжүүлэх, авлигыг устгах чиглэлээр боловсрол, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарсан цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Ёс зүйтэй Монгол хүн, Монгол нийгмийг төлөвшүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ. Нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх орчинг бүрдүүлнэ.
- Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгааг бууруулах, хөдөлмөрийн зах зээл дээр шинэ боломжийг нээж өгнө.
- Эмэгтэйчүүдийн далд дарангуйллыг устгах, хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэнэ.
- Ёс суртахууны доройтол, архидалт, мансуурал, садар самуун зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд тууштай тэмцэж нийгмийг эрүүлжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгааг нь хангана.
- Байгаль орчны болон хүнс, эм, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг эрс чангатгана.







## У. БИЗНЕСТ ЭЭЛТЭЙ ХОТ

*Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна*

Эдийн засаг, бизнест тэгш боломж, шударга өрсөлдөөнийг бий болгох зарчмыг мөрдлөг болгон, хөдөлмөрлөсөн нь сайхан амьдардаг, хичээсэн нь амжилт гаргадаг, боломж чадвараар дутуугаа гээдэггүй, хүний наад захын эрэлт хэрэгцээ хангагдсан, шударга нийгмийг цогцлон байгуулна.

- Иргэн бүрд жигд боломж, нөхцөлийг олгосон төсвийн өгөөжтэй зарцуулалтыг хэрэгжүүлж, авлигаас ангид бие даасан, хэсэг бүлэг этгээдийн шунал, хүсэлд захирагдаагүй сахилга баттай шударга чөлөөт зах зээлийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлж төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэл хийх бодлого баримтлана. Салбарын болон нийслэл, дүүргийн хэрэгцээ шаардлагыг бодитоор тооцоолж, улсын нийгэм эдийн засгийн хөгжилд түлхэц болох төслүүдийг эрэмбэлэн санхүүжүүлж, хөрөнгө оруулалтын шийдвэр болон санхүүжилтийг ил тод болгоно.
- Нийслэлийн төсвийн санхүүжилттэй нийтийн чанартай төсөл, нийслэлийн ханган нийлүүлэлтийн төслийн бараа үйлчилгээний тендер, худалдан авалтыг шударга явуулахад онцгой анхаарч, хэрэгжилтийг ил тод, нийтийн хяналтан дор явуулна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, үр чадвартай залуу үеийг төлөвшүүлж, бүрэн хөдөлмөр эрхлэлттэй улс болохын төлөөх бодлогыг нийслэлд хэрэгжүүлнэ.
- Эдийн засаг, бизнест хэт дарамт учруулахгүй, энгийн ойлгомжтой, үр нөлөө бүхий, шударга татварын тогтолцоог бий болгоно. Бизнесийн шударга орчин, шударга өрсөлдөөнийг бий болгоно.
- Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжиж, бага хүүтэй урт хугацааны зээл авах боломжоор хангах, ажлын байр нэмэгдүүлэх хөшүүрэг болгох арга хэмжээ авна.
- Дэлхийн шилдэг түршлагад (тухайлбал, Грамин банк) тулгуурласан “Бичил зээл”-ийн тогтолцоог бүрдүүлэхэд бодлогын болон хууль эрх зүйн дэмжлэг үзүүлнэ.
- Ядуурлаас гарахад зориулсан мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулж, сургалтыг төрийн зүгээс тогтмол явуулдаг болно. Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд орох боломжийг бүрдүүлэх, цаашлаад ажил хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.
- Бага насны хүүхэд ядууралд өртөх, хүнс тэжээлийн дутагдалд орох, орон гэргүйн улмаас амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал нь эрсдэх нөхцөл байдлыг арилгахыг зорино.







- Хотын хөгжил, дэд бүтэц, бүтээн байгуулалтыг дэмжих хөрөнгө оруулалтын бонд гаргах, нийслэлийн болон үл хөдлөх хөрөнгийн татварын зохистой хэмжээг тогтоож, хураамж, татвар цуглуулах шударга арга замыг хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд иргэдийн оролцоог бодит утгаар нь бий болгох, зарцуулалтад тавих олон нийтийн хяналтыг дэмжинэ.

### **Бизнес эрхлэлт, үйлдвэрлэлийн хөгжлийг бодлогоор дэмжинэ.**

- Бизнесийн салбарт бизнес эрхлэх шударга, тогтвортой орчинг бүрдүүлж, компанийн засаглал, бизнесийн ёс зүйг сайжруулж, зөвлөх үйлчилгээг дэмжинэ.
- Мэдлэг, инновацийг дээдэлсэн эдийн засгийн ач холбогдолтой бизнесийн төслүүдийг дэмжинэ. ЖДҮ-ийг дэмжих, гарааны бизнесүүдийг бойжуулах инкубаторуудыг байгуулах, өртөг багатай, бага хүүтэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар дэмжинэ.
- Бүх насны иргэдийн хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний холбоодыг хөгжүүлэх замаар ахмадуудын ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- Дотоодын нөөц бололцоогоор хийх боломжтой ажлын байрыг хамгаалж, өөрийн орны иргэдийг ажиллуулах, эрэлт хэрэгцээ өндөртэй болон ирээдүйд шинээр бий болох ажлын байруудад боловсон хүчнийг сургах, бэлтгэх бодлого баримтлана.
- Тэргүүний технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.
- Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан нийслэл, дүүргүүдийн ойролцоо эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх бодлого баримтлана.
- Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ. Нэн ялангуяа хонины ноосоор барилгын дулаалга, бордоо үйлдвэрлэхийг төрөөс зээл олгох замаар дэмжинэ.
- Хүйтнийг даван туулах технологийг бүхий л талаар дэмжин, дулаан алдагдал багатай барилгын материал үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлана.
- Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангаж, нийслэл, дүүргүүдийн ойр бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 30 хувь, сүүний 40 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулна.
- Хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Олон улсын туршлага, өөрийн орны боломж, нөхцөлд нийцүүлэн эдийн засгийн, экспортын, худалдааны чөлөөт бүсүүдийг нийслэлийн хэмжээнд хөгжүүлж,



үйлдвэрлэлийг төрөлжүүлэх бодлого баримтлана. Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.

### Аялал жуулчлал

- Жуулчдын статистик бүртгэл хөтлөх, судалгаа хийх тогтолцоог бэхжүүлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх бодлого баримтлана.
- Хотын соёл, түүхийн аялал жуулчлалыг дэмжих бодлого баримтална. Нийслэлийн орчимд байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал, нүүдлийн соёл иргэншлийг танилцуулах жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх бодлого баримтлана.
- Музей, соёл урлаг, түүх, уламжлалт зан заншилыг хамарсан зөөлөн хүчний бодлогыг аялал жуулчлалтай уялдуулна.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг Монгол орноороо аялах дотоодын аяллыг зохион байгуулах, музей, үзвэрийн газруудаар үйлчлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### Хөдөлмөрийн Үндэсний Нам

2020 он

